

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тендерийн дугаар: МРЦМ/20240101301

Тендерийн нэр: “Дизель станцаас Төв хуваарилах байгууламжруу 6кВ ЦДАШ барих”

“Бор-Өндөр” УБҮ-ийн ЦРП болон Баргилт хэсгийг Дизель цахилгаан станцаар тэжээх 6кВ “Цахилгаан дамжуулах агаарын шугам”-ын трассын зураг, зураг төсвийг гарган батлуулж, угсралт суурилуулалт тохиргооны ажлыг хийж гүйцэтгэнэ.

I. Хийгдэх ажил

1. Төмөр бетон тулгууруудыг шинээр угсран суурилуулж, агаарын шугамыг татах, газардуулга тавих, хүчдэл хязгаарлагч суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
2. Дизель станцын ХХБ№1 гаргалгааны сэлгэн залгалтын 6кВ-ын самбарыг вакуум таслуураар тоноглон ХХБ№2 болон Баргилтын 6кВ-ын ХХБ-ийг тэжээх.

II. Ашиглалтын нөхцөлийн шаардлага

1. Суурилуулалтын нөхцөл		гадаа
2. Температур	°C	- 30
3. Газар хөдлөлтийн зэрэг	балл	4-5
4. Бохирдлын зэрэг		III
5. Салхины хурд /10 жил 1 удаа/	м/сек	28
6. Харьцангуй чийгшил	%	70
7. Мөсжилтийн бүс		I-II
8. Чадал	МВт	3,2

III. Техникийн нөхцөлийн шаардлага

1. Бүх тулгуурт газардуулах байгууламжтай, газардуулгыг 4 тийш нь цацраг хэлбэртэйгээр тус бүр нь 25 м урттайгаар хийнэ.
 - 1.1 Газардуулгын эсэргүүцэл жилийн аль ч улиралд 30 Ом-оос ихгүй байна.
 - 1.2 10 кВ-ын хуурай салгуур суурилуулсан тулгуурын газардуулах байгууламжийн эсэргүүцэл 10 Ом-оос ихгүй байна.
 - 1.3 ЦДАШ-ыг MNS 587:2008 стандартын шаардлага хангасан АС маягийн гант хөнгөн цагаан утасаар хийж гүйцэтгэнэ.
 - 1.4 Нийлүүлэгдэх төмөр бетон тулгуур болон анкер нь стандартын шаардлага техникийн үзүүлэлт тус бүрээр хангаж буй эсэхийг баталгаажуулсан тухайн чиглэлээр туршилт явуулах эрх бүхий үйлдвэрлэгчээс үл хамаарах туршилтын лабораторийн гэрчилгээ протокол, тохирлын гэрчилгээтэй байх ёстой.
 - 1.5 6-10 кВ-ын агаарын шугамд: 50 кН·м-ээс багагүй мурийлгах моменттой төмөр бетон тулгуур, 40 жилээс багагүй хугацаанд ажиллах чадвартай.
 - 1.6 Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур нь төмөр бетон конусан 12м урттай байна.
 - 1.7 Бүх нийлүүлэгдэх төмөр бетон тулгуур нь үйлдвэрээс газардуулга холбох зориулалт бүхий тольтой байх ёстой. Нийлүүлэгдэх төмөр бетон тулгуур нь стандартын шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй байх ёстой.
 - 1.8 Тулгуур нь MNS:4232-2011 стандартын шаардлага хангасан тросон арматураар урьдчилан хүчилтгэсэн залгаасгүй төмөр бетон тулгуур хэрэглэх. Нийлүүлэгдэх тулгуурууд тохирлын гэрчилгээтэй, худалдан авалтын өмнө ба дараа туршилт хийж баталгаажуулсан байх ёстой.

- 1.9 Тулгуур хэрэглэгдэх бүх металл эд анги үйлдвэрийн нөхцөлд халуунаар эсвэл термодиффузийн аргаар цайрдагдсан байх ёстой ба бусад зэврэлтээс хамгаалах аргыг (цайрын өнгөөр будах г.м) зөвшөөрөхгүй.
- 1.10 Төмөр бетон тулгуур нь нэмэлт газардуулгын буулт утас хэрэглэхгүйгээр тулгуурын орой хэсэгт мөн газарт булагдах хэсгээс 50 см-аас хэтрэхгүй өндөрт газардуулах байгууламж холбох шигтгэмэл төмөр хавтантай байх ёстой.

Дизель станцаас Төв хувиарлах байгууламж руу татах 6кВ ЦДАШ-ын трассын бүлүүвч зураг 0.46 км

